



ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот
Утас: +976-77111500

2025-2026 оны хичээлийн жилд суралцагч
элсүүлэх журам батлах тухай

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/143 дугаар тушаалаар баталсан "Оюутан элсүүлэх журам", Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн "Сургалтын журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хүмүүнлэгийн ухааны их сургуульд 2025-2026 онд суралцагч элсүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.


2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Элсэлтийн комисс /Б.Галбадрах/, сургалтын алба /Б.Урансайхан/, Санхүүгийн алба /Г.Сэргэлэн/, Мэдээллийн технологийн алба /С.Диваасамбуу/-д тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ



Б.ЧУЛУУНДОРЖ

Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн захирлын
2025 оны 06 дугаар сарын 17 ны өдрийн
А/62 тоот тушаалын хавсралт



ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 БШУЯ-аас батлан гаргасан 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/143 тоот "Оюутан элсүүлэх журам", 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/228 тоот "Босго оноо тогтоох" тушаал, Хүмүүнлэгийн ухааны их сургууль (цаашид "Сургууль" гэх)-ийн "Сургалтын журам"-ыг үндэслэн Сургуульд суралцагч элсүүлэн суралцуулна.
- 1.2 Энэхүү журмаар элсэгчдэд тавигдах шаардлага, элсэлтийн зохион байгуулалт, сонгон шалгаруулалт, сургалтын төлбөр, хураамж зэрэг элсэлттэй холбогдох харилцааг зохицуулна.
- 1.3 Элсэгчийн тоо бакалаврын өдрийн хөтөлбөрт 30, бакалаврын оройн хөтөлбөрт 8, магистрын хөтөлбөрт 10, докторын хөтөлбөрт 1-ээс дээш тохиолдолд бүлэг бүрдэж, тухайн хөтөлбөрөөр сургалт зохион байгуулна.
- 1.4 Тухайн жилийн хяналтын тоонд үндэслэн тодорхой хөтөлбөрт өвлийн улиралд нэмэлт элсэлтийг зохион байгуулж болно.
- 1.5 Өмнө нь эзэмшсэнээс өөр чиглэлээр магистр, докторын зэргийн хөтөлбөрт суралцахыг хүссэн элсэгчид сургалтын агуулгын залгамж, чанарыг хангахад шаардагдах зөрүү хичээлийг мэргэжлийн тэнхимийн санал, зөвшөөрөл дээр үндэслэн судална. Эдгээр хичээлийн багц цаг нь магистр, докторын зэрэг олгох үндсэн ачаалалд тооцогдохгүй.
- 1.6 Бүртгүүлэгч өөрийн хувийн мэдээллийн үнэн, зөв, бүрэн байдлыг бүрэн хариуцна.
- 1.7 Сургуульд элсэхийг хүссэн гадаадын харьяат иргэний элсэлтийн үйл ажиллагааг Сургуулийн "Гадаадын иргэнийг суралцуулах журам"-аар зохицуулна.
- 1.8 Энэхүү журмаар зохицуулагдах боломжгүй асуудлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомж дүрэм журмын дагуу шийдвэрлэнэ.

Хоёр. Нэр томьёо

- 2.1 "Бүртгүүлэгч"-Сургуулийн бакалавр, магистр, докторын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэн.
- 2.2 "Элсэгч"-элсэх шалгуур ханган "Суралцагч суралцуулах гэрээ" хийн баталгаажуулсан бүртгүүлэгч.
- 2.3 "Элсэлтийн комисс"-Захирлын тушаалаар томилогдсон элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах бүрэлдэхүүн.

- 2.4 “Хяналтын тоо”-Сургуулийн Удирдах зөвлөлийн баталсан 2025-2026 оны хичээлийн жилд элсүүлэх суралцагчийн тоо.

Гурав. Элсэлтийн комиссын эрх, үүрэг

3.1 Эрх

- 3.1.1 Элсэлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, бусад алба, нэгжүүдтэй хамтран ажиллах;
- 3.1.2 Энэхүү журмыг мөрдлөг болгон бусдаас үл хамааран, бие даан шалгаруулалт хийн шийдвэр гаргах;
- 3.1.3 Энэхүү журмын 1.3 дугаар заалтын дагуу бүлэг бүрдээгүй хөтөлбөрийг хаах;
- 3.1.4 Хяналтын тоонд хүрээгүй хөтөлбөрүүдэд нэмэлт элсэлт зохион байгуулах;
- 3.1.5 Энэхүү журмаар зохицуулагдахгүй элсэлттэй холбогдох маргаан, гомдол, асуудлыг зохих дүрэм, журмын дагуу шийдвэрлэх;
- 3.1.6 Элсэгчдэд тавигдах шаардлага хангаагүй, ёс бусаар хандсан бүртгүүлэгч, асран хамгаалагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

3.2 Үүрэг

- 3.2.1 Үйл ажиллагаандаа “Боловсролын ерөнхий хууль”, “Дээд боловсролын тухай” хууль бусад холбогдох хууль болон энэхүү журмыг мөрдлөг болгох;
- 3.2.2 Удирдах зөвлөлийн баталсан хяналтын тоонд багтаан суралцагч элсүүлэх;
- 3.2.3 Элсэлттэй холбогдох мэдээллийг сургуулийн цахим хуудас <http://www.humanities.edu.mn>, бүртгэлийн систем, нийгмийн сүлжээ, утас, элсэлтийн комиссын цахим шуудангаар тухай бүр мэдэгдэх;
- 3.2.4 Элсэгчдийг бүртгэх, сонгон шалгаруулах ажлыг удирдах, зохион байгуулах, элсэгчдээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх, элсэлтийн дүн мэдээг гаргах;
- 3.2.5 Энэхүү журмын 3.1.3 дугаар заалтын дагуу гарсан шийдвэрийг тухай бүр бүртгүүлэгчдэд мэдэгдэж, шийдвэрлэх;

Дөрөв. Элсэгчдэд тавигдах шаардлага

- 4.1 Элсэгч нь “Суралцагч суралцуулах гэрээ” болон Сургуулийн “Сургалтын журам”, “Сургалтын төлбөр тооцооны журам”-тай танилцсан байх,

4.2 Бакалаврын өдрийн хөтөлбөр

- 4.2.1 Боловсролын үнэлгээний төв (цаашид “БҮТ” гэх)-д бүртгэлтэй, энэхүү журмын **Хавсралт-1**-д заасан хичээлээр 2023, 2024, 2025 онд элсэлтийн шалгалт (цаашид “ЭШ” гэх)-ын харгалзах шалгуурыг хангасан байх,

4.3 Бакалаврын өдрийн хөтөлбөрт ЭШ оноо шаардахгүйгээр элсүүлэх

- 4.3.1 Дэд бакалавр, бакалаврын зэрэгтэй,
- 4.3.2 Политехник коллеж, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын боловсролын зэрэгтэй,

- 4.3.3 Тухайн чиглэлийн хөтөлбөрт боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 медальт байрын батламжтай,
- 4.3.4 Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшин, олон улсад хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноог Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаар дүйцүүлэн тооцуулсан батламжтай,
- 4.3.5 Элсэн суралцах мэргэжлийн чиглэл/хөтөлбөр/-ээр сүүлийн 3-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш настай байх,
- 4.4 Бакалаврын оройн хөтөлбөр**
 - 4.4.1 Бакалаврын зэрэгтэй,
 - 4.4.2 Англи хэлний элсэлтийн шалгалт өгч 60% буюу түүнээс дээш үнэлгээ авсан байх,
- 4.5 Магистр, докторын хөтөлбөр**
 - 4.5.1 Магистрын хөтөлбөрт бакалаврын зэрэгтэй, үнэлгээний голч нь 2.0 ба түүнээс дээш байх,
 - 4.5.2 Докторын хөтөлбөрт судалгааны ажил гүйцэтгэж байсан туршлагатай, магистрын зэрэгтэй, үнэлгээний голч нь 3.0 ба түүнээс дээш байх,
 - 4.5.3 Англи хэлний элсэлтийн шалгалт өгч 80% буюу түүнээс дээш үнэлгээ авсан байх,
- 4.6 Гадаадын иргэн**
 - 4.6.1 Тухайн хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу Монгол улсад мөрдөгдөж буй стандарттай дүйцэх боловсрол эзэмшсэн байх,
 - 4.6.2 Монгол хэлний анхан шатны сургалтад хамрагдсан нотлох баримттай байх эсвэл Монгол хэлний анхан шатны элсэлтийн шалгалтад 80% буюу түүнээс дээш үнэлгээ авсан байх,
 - 4.6.3 Англи хэл дээр хэрэгждэг хөтөлбөрт тавигдах боловсролын шаардлага мөн Англи хэлний шалгалтад 80% буюу түүнээс дээш үнэлгээ авсан байх,

Тав. Хөтөлбөрт бүртгүүлэх

- 5.1 Бүртгүүлэгч нь энэхүү журам болон бусад холбогдох журмуудтай танилцаж хүлээн зөвшөөрснөөр элсэлтийн үйл ажиллагаанд оролцоно.
- 5.2 Бүртгүүлэгч Сургуулийн цахим хуудас болох <https://www.humanities.edu.mn/> хаягаар элсэлтийн системд нэвтэрч өөрийн бүртгэлийг үүсгэнэ.
- 5.3 Бүртгэлийн хураамж **50.000 төгрөг** байна. Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй. Бүртгэл баталгаажуулсан тохиолдолд бүртгэлийн хураамжийг дараагийн улирлын сургалтын төлбөрт шилжүүлэн тооцно.
- 5.4 Бүртгүүлэгч холбогдох мэдээлэл болон шаардагдах материалыг энэхүү журмын 5.7.1 хэсэгт заасан хугацаанд бүрэн оруулсан тохиолдолд тухайн хөтөлбөрт бүртгүүлсэнд тооцно.

5.5 Бүртгэл баталгаажуулсан тохиолдолд хөтөлбөр сонголтод өөрчлөлт оруулах боломжгүй болно.

5.6 Бүртгүүлэгч шалгаруулалтын үр дүнг өөрийн цахим шуудан болон элсэлтийн системд нэвтэрч хянана.

5.7 Бакалаврын өдрийн хөтөлбөр

5.7.1 Бүртгэлийг **2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн** хооронд хүлээн авна. Өвлийн улирлын элсэлтийн бүртгэлийг **2025 оны 11 дүгээр сарын 25-аас өвлийн ЭШ-ын сүүлийн өдөр хүртэл** хүлээн авна.

5.7.2 Бүртгүүлэгч БҮТ-ийн системд нэвтрэх бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан элсэлтийн системд нэвтэрч, хувийн мэдээллээ зааврын дагуу үнэн зөв оруулж бүртгүүлнэ.

5.8 Бакалаврын оройн хөтөлбөр

5.8.1 Бүртгэлийг **2025 оны 07 дугаар сарын 01-ээс 2025 оны 08 дугаар сарын 31-ний** хооронд хүлээн авна.

5.8.2 Бакалаврын оройн хөтөлбөрийн элсэлтийг зөвхөн намрын улиралд зохион байгуулна.

5.8.3 Бүртгүүлэгч элсэлтийн системд бүртгэл үүсгэж дараах мэдээллийг зааврын дагуу оруулна. Үүнд:

- Иргэний үнэмлэхийн хуулбар эсвэл лавлагаа;
- Бакалаврын зэргийн диплом, түүний хавсралт (Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд бүртгэлтэй байх, мөн гадаадад төгссөн бол албан ёсны орчуулга хийлгэж, нотариатаар баталгаажуулсан, БМИҮЗ-ээр баталгаажуулалт хийлгэсэн байх);

5.9 Магистр, докторын хөтөлбөр

5.9.1 Бүртгэлийг **2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 16-ны** хооронд хүлээн авна. Өвлийн улирлын элсэлтийн бүртгэлийг **2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн** хооронд хүлээн авна. Бүртгүүлэгч элсэлтийн системд бүртгэл үүсгэж дараах мэдээллийг зааврын дагуу оруулна. Үүнд:

Магистрын хөтөлбөр

- Иргэний үнэмлэхийн хуулбар эсвэл лавлагаа;
- Бакалаврын зэргийн диплом, түүний хавсралт (Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд бүртгэлтэй байх, мөн гадаадад төгссөн бол албан ёсны орчуулга хийлгэж, нотариатаар баталгаажуулсан, БМИҮЗ-ээр баталгаажуулалт хийлгэсэн байх);

Докторын хөтөлбөр

- Иргэний үнэмлэхийн хуулбар эсвэл лавлагаа;
- Магистрын зэргийн диплом, түүний хавсралт (Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд бүртгэлтэй байх, мөн гадаадад төгссөн

бол албан ёсны орчуулга хийлгэж, нотариатаар баталгаажуулсан, БМИҮЗ-ээр баталгаажуулалт хийлгэсэн байх)

- Бүтээлийн жагсаалт;

5.10 Гадаадын иргэн

5.10.1 Бүртгэлийг **2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 20-ны** хооронд хүлээн авна. Өвлийн улирлын элсэлтийн бүртгэлийг **2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн** хооронд хүлээн авна. Бүртгүүлэгч элсэлтийн системд бүртгэл үүсгэж дараах мэдээллийг зааврын дагуу оруулна. Үүнд:

- Гадаад паспортын хуулбар, баталгаат орчуулгын хамт;
- Өмнө нь эзэмшсэн боловсролын түвшнийг илтгэх гэрчилгээ, диплом, дүнгийн хуулбар /баталгаат орчуулгаар орчуулсан байх/;
- Суралцах хүсэлтээ илэрхийлсэн өргөдөл /Монгол хэлээр/;
- Эрүүл мэндийн магадалгааг холбогдох эмнэлгийн байгууллагаар баталгаажуулсан байх;

Зургаа. Суралцагч элсүүлэн шалгаруулах

6.1. Бакалаврын өдрийн хөтөлбөр

- 6.1.1. БШУЯ-ны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/170 тоот тушаал, энэхүү журмын **Хавсралт 1-д** заасан шалгуурыг үндэслэн шалгаруулна.
- 6.1.2. Элсэлтийн комисс 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдөр /өвлийн элсэлтийн хувьд ЭШ-ын сүүлийн өдөр/ хүртэл хүсэлт илгээсэн нийт бүртгүүлэгчийн Элсэлтийн шалгалтын нийлбэр оноогоор жагсаан тухайн хөтөлбөрийн хяналтын тоогоор тасалбар болгох зарчим баримтална.
- 6.1.3. Бүртгүүлэгчийн Элсэлтийн шалгалтын нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд Элсэлтийн шалгалтын 1 дүгээр хичээлийн оноогоор жагсаан эрэмбэлнэ. Хэрэв 1 дүгээр хичээлийн оноо тэнцвэл Бүрэн дунд боловсролын гэрчилгээний улсын шалгалтын үнэлгээний дунджаар жагсаан эрэмбэлнэ.
- 6.1.4. Шалгарсан бүртгүүлэгч “Суралцагч суралцуулах гэрээ”-ний нөхцөлийг хүлээн зөвшөөрч нэхэмжлэлийн дагуу сургалтын төлбөр бүрэн төлсөн өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.
- 6.1.5. Гэрээ хүчин төгөлдөр болсон дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ.
- 6.1.6. Хяналтын тоонд багтсан элсэгч, эцэг эх, асран хамгаалагчийн хамт цахим шуудангаар илгээх удирдамжийн дагуу хичээлийн жилийн чиглүүлэх сургалтад заавал хамрагдана.
- 6.1.7. Элсэгч чиглүүлэх сургалтад хамрагдахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж Сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Гарын үсэг зурж албажуулсан “Суралцагч суралцуулах гэрээ”;
 - Иргэний цахим үнэмлэхийн хуулбар эсвэл лавлагаа;
 - Элсэлтийн шалгалтын батламж;
 - Бүрэн дунд боловсролын гэрчилгээ;

- Цээж зураг /хэмжээ 3x4, 2 хувь/;
- Элсэгч 19 нас хүрсэн бол эрүүл мэндийн даатгалд хамрагдан шимтгэл төлсөн баримт (2025 оны 09 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ийг дуустал хамрагдсан байх);

6.1.8 Энэхүү журмын 4.3.1, 4.3.2, 4.3.3, 4.3.4-т заасан элсэгч 2025 оны 08 дугаар сарын 25-ны дотор Сургалтын албанд өөрийн биеэр дараах бичиг баримтыг бүрдүүлэн ирнэ. Үүнд:

- Иргэний цахим үнэмлэхийн хуулбар эсвэл лавлагаа;
- Цээж зураг /хэмжээ 3x4, 2 хувь/;
- Өмнөх боловсролын гэрчилгээ; (Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд бүртгэлтэй байх, мөн гадаадад төгссөн бол албан ёсны орчуулга хийлгэж, нотариатаар баталгаажуулсан, БМИҮЗ-ээр баталгаажуулалт хийлгэсэн байх) эсвэл медальт байрт шалгарсан батламж, дүйцүүлэн тооцуулж авсан батламж,

6.1.9 Энэхүү журмын 4.3.5-т заасан элсэгч 2025 оны 08 дугаар сарын 25-ны /өвлийн элсэлтийн хувьд 2026 оны 1 дүгээр сарын 25-ны/ дотор Сургалтын албанд өөрийн биеэр дараах бичиг баримтыг бүрдүүлэн ирнэ. Үүнд:

- Иргэний цахим үнэмлэхийн хуулбар эсвэл лавлагаа;
- Цээж зураг /хэмжээ 3x4, 2 хувь/;
- Ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгал төлсөн лавлагаа
- Суралцах бэлтгэл хангасан, авьяас чадвар, туршлага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлсэн элсэн суралцах өргөдөл

6.2. Магистр, докторын хөтөлбөр

6.2.1. Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам болон 5.9.1-т заасан бүртгүүлэгчийн материалыг үндэслэн энэхүү журмын **Хавсралт-2-д** заасан шалгуураар шалгаруулна.

6.2.2. Англи хэлний чадварын шалгалтыг бүртгүүлэгч бүртгэл үүсгэх явцад удирдамжийн дагуу өгсөн байх.

6.2.3. Элсэлтийн комисс 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр /өвлийн элсэлтийн хувьд 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр/ хүртэл хүсэлт илгээсэн нийт бүртгүүлэгчийн боловсролын зэргийн голч, Англи хэлний шалгалтын оноо, докторын хөтөлбөрийн хувьд нэмэлтээр судалгааны бүтээл, туршлагыг, харгалзан жагсаан тухайн хөтөлбөрийн хяналтын тоогоор тасалбар болгох зарчим баримтална.

6.2.4. Шалгарсан бүртгүүлэгч “Суралцагч суралцуулах гэрээ”-ний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, нэхэмжлэхийн дагуу **2025 оны 09 дүгээр сарын 16-аас 2025 оны 09 дүгээр сарын 23-ны** хооронд /өвлийн элсэлтийн хувьд 2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс өмнө/ сургалтын төлбөр бүрэн төлсөн өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.

6.2.5. Гэрээ хүчин төгөлдөр болсон дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

6.2.6. Хяналтын тоонд багтсан элсэгч цахим шуудангаар илгээх удирдамжийн дагуу хичээлийн жилийн чиглүүлэх сургалтад заавал хамрагдана.

- 6.2.7. Элсэгч дараах бичиг баримтыг бүрдүүлж гэрээний дагуу 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор /өвлийн элсэлтийн хувьд 2026 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр/ Сургалтын албанд хуваарийн дагуу хүлээлгэн өгсөн байх,
- Гарын үсэг зурж баталгаажуулсан Суралцагч суралцуулах гэрээ;
 - Иргэний цахим үнэмлэхийн хуулбар эсвэл лавлагаа;
 - Цээж зураг /хэмжээ 3x4, 2 хувь/;
 - Өмнөх боловсролын гэрчилгээ;
- 6.2.8. Суралцах эрх үүссэн эсэхийг бүртгүүлэгчид шалгалт өгсөн өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан элсэлтийн системээр дамжуулан мэдэгдэнэ.

6.3. Гадаадын иргэн

- 6.3.1. Гадаад оюутан элсэх, суралцахтай холбоотой бусад харилцааг "Хүмүүнлэгийн ухааны их сургуульд гадаадын иргэн суралцуулах журам"-ийг үндэслэн энэхүү журмын Хавсралт 1, Хавсралт 2-т заасан шалгууртай дүйцүүлэн Монгол хэлний шалгалтын оноог үндэслэн шалгаруулна.
- 6.3.2. Монгол хэлний чадварын шалгалтыг бүртгүүлэгч бүртгэл үүсгэх явцад удирдамжийн дагуу өгсөн байх,
- 6.3.3. Элсэлтийн комисс 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр /өвлийн элсэлтийн хувьд 2026 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр/ хүртэл хүсэлт илгээсэн нийт бүртгүүлэгчийн боловсролын зэргийн голч, Монгол хэлний шалгалтын оноог харгалзан жагсаан тухайн хөтөлбөрийн хяналтын тоогоор тасалбар болгох зарчим баримтална.
- 6.3.4. Шалгарсан бүртгүүлэгч "Суралцагч суралцуулах гэрээ"-ний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, нэхэмжлэхийн дагуу **2025 оны 08 дугаар сарын 20-оос 2025 оны 08 дугаар сарын 27-ны** /өвлийн элсэлтийн хувьд 2026 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр/ хооронд сургалтын төлбөр төлсөн өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.
- 6.3.5. Гэрээ хүчин төгөлдөр болсон дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ.
- 6.3.6. Хяналтын тоонд багтсан элсэгч цахим шуудангаар илгээх удирдамжийн дагуу хичээлийн жилийн чиглүүлэх сургалтад заавал хамрагдана.
- 6.3.7. Элсэгч дараах бичиг баримтыг бүрдүүлж гэрээний дагуу 2025 оны 09 дүгээр сарын 30-ны /өвлийн элсэлтийн хувьд 2026 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр/ дотор Сургалтын албанд хуваарийн дагуу хүлээлгэн өгсөн байх,
- Гарын үсэг зурж баталгаажуулсан Суралцагч суралцуулах гэрээ;
 - Цээж зураг /хэмжээ 3x4, 2 хувь/;
 - Гадаад паспортын хуулбар, баталгаат орчуулгын хамт;
 - Өмнө нь эзэмшсэн боловсролын түвшнийг илтгэх гэрчилгээ, диплом түүний дүнгийн хуулбар /баталгаат орчуулгаар орчуулсан байх/;
 - Суралцах хүсэлтээ илэрхийлсэн өргөдөл /Монгол хэлээр/;
 - Эрүүл мэндийн магадалгааг холбогдох эмнэлгийн байгууллагаар баталгаажуулсан байх;

Долоо. Төлбөр тооцоо

- 7.1. Шалгуур хангасан элсэгчид төлбөрийн хэмжээ, төлбөр төлөх хугацаа, дансны мэдээлэл, гүйлгээний утга (Суралцагчийн регистрийн дугаар, овог, нэр)-ыг багтаасан тухайн хөтөлбөрийн сургалтын төлбөрийн нэхэмжлэхийг элсэлтийн системээр илгээнэ.
- 7.2. Гэрээнд заасан хугацаанд нэхэмжлэхийн дагуу төлбөр тооцоо хийгдсэн эсэхээс хамаарч Суралцагч суралцуулах гэрээ хүчин төгөлдөр болно.
- 7.3. Суралцагч суралцуулах гэрээ байгуулсан элсэгч гэрээг цуцлах хүсэлт гаргасан тохиолдолд 100,000 төгрөгийг суутгаж төлбөрийг буцаан олгоно.
- 7.4. Дараах нөхцөлийг хангасан тохиолдолд харгалзах эхний улирлын төлбөрийн хөнгөлөлтийг дараа улирлын сургалтын төлбөрт шилжүүлэн тооцно. Доорх хөнгөлөлтийг суралцсан хугацааны хуримтлуулсан голч нь 3.70-оос дээш дүнтэй, тасралтгүй суралцсан суралцагч нийт суралцах хугацаанд үргэлжлүүлэн эдлэх боломжтой.

Шалгалт 1, Шалгалт 2-ын нийлбэр оноо	Хөнгөлөлтийн хувь
1,280 -1,339	20%
1,340 -1,399	40%
1,400 -1,439	60%
1,440 -1,499	80%
1,500 -1,600	100%

- 7.5. Бүлэг бүрдэлтээс хамааран сургалт зохион байгуулагдаагүй тохиолдолд сургалтын төлбөрийг 100% буцааж олгож "Суралцагч суралцуулах гэрээ"-г дуусгавар болгоно.

Сургуулийн цахим хуудас: <https://www.humanities.edu.mn/>
Элсэлтийн комиссын И-мэйл: admission@humanities.mn
Утас: 7711-1500

---000---

ХИС – ИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ 2025-2026
ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, Элсэлтийн
шалгалтын босго оноо

Монгол хэл бичгийн шалгалт өгч үндэсний босго онооны шалгуурыг хангасан байна


№	Индекс	ХӨТӨЛБӨР	ЭШ 1 хичээл	Оноо 1	ЭШ 2 хичээл	Оноо 2
1	023101	Гадаад хэлний орчуулга - Англи		490	Монгол хэл, Нийгэм судлал	490
2	011435	Багш гадаад хэлний боловсрол - Англи	Англи хэл, Орос хэл	490	Ур чадварын шалгалт	490
3	031202	Олон улсын харилцаа		490	Түүх, Нийгэм судлал	490
4	032101	Сэтгүүл зүй	Монгол хэл, Нийгэм судлал	490	Ур чадварын шалгалт	490
5	032101	Сэтгүүл зүй (2+2 хөтөлбөр)	Монгол хэл, Нийгэм судлал	490	Ур чадварын шалгалт	490
6	031301	Сэтгэл судлал	Нийгэм судлал, Математик	520	Англи хэл, Монгол хэл	500
7	041301	Бизнесийн удирдлага		490		490
8	041301	Бизнесийн удирдлага (Эдийн засаг)		490		490
9	041301	Бизнесийн удирдлага (Нягтлан бодох бүртгэл)	Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	490
10	041401	Маркетинг		490		490
11	041201	Санхүү, банк		490		490
12	061302	Программ хангамж	Физик, Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	450
13	061302	Программ хангамж (3+1 хөтөлбөр)	Физик, Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	450
14	101501	Аялал жуулчлал	Математик, Газарзүй	490	Англи хэл, Нийгэм	490

					судлал	490
15	101501	Аялал жуулчлал (2+2 хөтөлбөр)	Математик, Газарзүй	490	Англи хэл, Нийгэм судлал	490




---000---

Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн
суралцагч элсүүлэх журмын
2 дугаар хавсралт



**ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН ОРОЙН БАКАЛАВР,
МАГИСТР, ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТ 2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН
ЖИЛД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД**

№		Хөтөлбөр түвшин	Шалгуур
ОРОЙН БАКАЛАВР			
1	023101	Гадаад хэлний орчуулга (Англи хэл)	B2 түвшний Англи хэлний шалгалт
МАГИСТР			
1	041301	Бизнесийн удирдлага	B2 C1 түвшний англи хэлний шалгалт
2	011101	Боловсрол судлал	
3	031202	Олон улсын харилцаа	
4	023203	Гадаад хэл шинжлэл	
5	031301	Сэтгэл судлал	
6	061302	Программ хангамж	
ДОКТОР			
1	041301	Бизнесийн удирдлага	B2 C1 түвшний англи хэлний шалгалт + Бүтээлийн жагсаалт
2	041303	Менежмент	
3	031202	Олон улсын харилцаа	
4	022203	Олон улс, орон судлал	
5	023203	Гадаад хэл шинжлэл	
6	011101	Боловсрол судлал	



СЭТГҮҮЛ ЗҮЙ ХӨТӨЛБӨРИЙН УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

- 1.1. Ур чадварын шалгалт зохион байгуулах удирдамжийг ХИС-ийн сэтгүүл зүйн хөтөлбөрт элсэхийг хүсэгчдэд ур чадварын шалгалт өгөх, ур чадварын шалгалт зохион байгуулах багш нарыг мэдээллээр хангах, үйл ажиллагааг чиглүүлэхэд оршино
- 1.2. Ур чадварын шалгалтын үнэлгээг мэргэжлийн тэнхимээс томилогдсон багш нар өгнө.
- 1.3. Сэтгүүл зүйн мэргэжлээр суралцахыг хүссэн хэн бүхний мэдлэг, ур чадвар, авьяасыг нээн илрүүлэх мөн энэхүү мэргэжлээр цаашид суралцах чин хүсэл эрмэлзэл бүхий суралцагчийг сонгон шалгаруулах зорилготой шалгалтын цогц үйл ажиллагаа юм.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа

- 2.1. Ур чадварын шалгалтад ХИС-ийн элсэлтийн бүртгэлд **Ур чадварын шалгалт** өгөхөөр бүртгүүлсэн ЕБС-ийн 12 дугаар ангийн төгсөгч, бүрэн дунд боловсролтой иргэн
- 2.2. Ур чадварын шалгалтыг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр /өвлийн элсэлтийн хувьд ЭШ-ын сүүлийн өдөр/ хүртэлх хугацаанд авна.

Гурав. Үйл ажиллагааны дараалал

Ур чадварын шалгалтыг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

- 3.1. **Ур чадварын шалгалтын бүртгэл:** Элсэгч элсэлтийн бүртгэлийн <https://elselt.humanities.edu.mn/Course/Detail/16> веб хуудсанд Сэтгүүл зүйн хөтөлбөрт элсэхээр бүртгүүлснээр шалгалт өгөх эрхтэй болно.
- 3.2. Ур чадварын шалгалтыг онлайнаар авах шалгалт дараах хэсгээс бүрдэнэ.

Эсээ бичих: Өгөгдсөн 3 сэдвээс сонголт хийж дурын нэг сэдвээрээ эсээ бичнэ.

Эсээнд тавигдах шаардлага:

- 300-500 үгэнд багтаан монгол хэлээр бичих (Хуудасны хэмжээ -A4, үсгийн фонт -arial, үсгийн өндөр -12pt, мөр хоорондын зай 1.5 байна.)



- Эсээний агуулга нь сэдэвтэйгээ уялдсан байх
- Эсээ бичлэгийн ерөнхий шалгуур, хэл найруулгын шаардлагыг хангасан байх
- Ашигласан эх сурвалжаа тодорхой дурдах
- Эсээ нь гаргалгаа, нотолгоо, дүгнэлт сайтай, зохиогчийн үзэл санааг бүрэн илэрхийлсэн байх


Үнэлгээ:

Үгийн тоо 300-500	5
Үг үсгийн алдаа	5
Бичгийн стандарт	10
Эх сурвалжаа дурдсан байдал	10
Агуулгаа бүрэн илэрхийлсэн байдал	10
Шинэлэг санаа	10
Найруулга зүй	10
Логик дэс дараалал	10
Баримт нотолгоо дээр тулгуурласан байдал	10
Энгийн ойлгомжтой байдал	10
Уншихад сонирхолтой байдал	10
Нийт	100

Үр дүнг тайлагнах

Бүртгүүлэгчдийн ур чадварын шалгалтын оноог 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр /өвлийн элсэлтийн хувьд ЭШ-ын сүүлийн өдөр/ ХИС-ийн Элсэлтийн бүртгэлийн системд бүрэн оруулсан байна.

---000---



**“БАГШ ГАДААД ХЭЛНИЙ БОЛОВСРОЛ - АНГЛИ” БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ
ЭЛСЭГЧЭЭС АВАХ УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

Ерөнхий шаардлага

Бүрэн дундаас доошгүй боловсрол эзэмшсэн байна. “Багш, гадаад хэлний боловсрол - Англи хэл” хөтөлбөрт элсэхэд Англи хэл эсвэл Орос хэлний ЭШ заавал өгч 490 ба түүнээс дээш оноотой байна. “Багш гадаад хэлний боловсрол - Англи” хөтөлбөрт элсэгчид ур чадварын шалгалт өгнө. Ур чадварын шалгалт нь хандлага, ёс зүйг тодорхойлох тест болон эсээ бичлэг гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Нэг. Зорилго

- 1.1. Ур чадварын шалгалт зохион байгуулах удирдамж нь ХИС-ийн “Багш гадаад хэлний боловсрол - Англи” хөтөлбөрт элсэх хүсэлт илгээсэн этгээдээс ур чадварын шалгалт а, ур чадварын шалгалт зохион байгуулах багш нарыг мэдээллээр хангах, үйл ажиллагааг чиглүүлэхэд оршино. “Багш гадаад хэлний боловсрол - Англи” хөтөлбөрт суралцахыг хүссэн хэн бүхний мэдлэг, ур чадвар, авьяасыг нээн илрүүлэх мөн энэхүү мэргэжлээр цаашид суралцах чин хүсэл эрмэлзэл бүхий суралцагчийг сонгон шалгаруулах зорилготой шалгалтын цогц үйл ажиллагаа юм.
- 1.2. Ур чадварын шалгалтын үнэлгээг мэргэжлийн тэнхимээс томилогдсон шалгагч багш нар өгнө.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа

- 2.1. Ур чадварын шалгалтад Англи эсвэл Орос хэлний ЭШ-ын 490 ба түүнээс дээш оноотой, ХИС-ийн элсэлтийн бүртгэлд “Багш гадаад хэлний боловсрол - Англи” хөтөлбөрт бүртгүүлсэн, ЕБС-ийн 12 дугаар ангийн төгсөгч, бүрэн дунд боловсролтой иргэн хамрагдана.
- 2.2. Ур чадварын шалгалтыг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр /өвлийн элсэлтийн хувьд ЭШ-ын сүүлийн өдөр/ хүртэлх хугацаанд авна.

Гурав. Үйл ажиллагааны дараалал

Ур чадварын шалгалтыг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

- 3.1. Ур чадварын шалгалтын бүртгэл: Элсэгч элсэлтийн бүртгэлийн веб хуудсанд “Багш гадаад хэлний боловсрол - Англи” хөтөлбөрт элсэхээр бүртгүүлснээр шалгалт өгөх эрхтэй болно.
- 3.2. Ур чадварын шалгалтыг онлайнээр зохион байгуулах бөгөөд дараах хэсгээс бүрдэнэ.

Ур чадварын онлайн шалгалтын бүтэц

3.2.1 Хандлага, ёс зүйг тодорхойлох тест (40%)

Агуулга: Англи хэлний багш мэргэжлийн хандлага, ёс зүйг шалгана.

Хэлбэр: Google form тест хэлбэрээр онлайнээр авна.

Нийт оноо: 45 оноо (15 асуулт, асуулт бүр 3 оноотой)

Үнэлгээ:

- **40-45 оноо:** Маш эерэг хандлагатай, ёс зүйн өндөр мэдрэмжтэй
- **30-39 оноо:** Сайн түвшин, хөгжих боломжтой
- **20-29 оноо:** Хандлага, ёс зүйн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай
- **0-19 оноо:** Сэрэмжлүүлэг: мэргэжлийн чиг баримжаа, ёс зүй сул

3.2.2 Эсээ бичлэг (60%)

Сэдэв сонголт: Элсэгч багш мэргэжлийн хандлага, ёс зүй, орчин үеийн чиг хандлагатай холбоотой өгөгдсөн гурван сэдвээс нэгийг сонгон эсээ бичнэ.

Хэл: Монгол эсвэл Англи хэлээр бичих боломжтой (Хуудасны хэмжээ -A4, үсгийн фонт -arial, үсгийн өндөр -12pt, мөр хоорондын зай 1.5 байна.)


Үгийн тоо: 250-300 үг.

Агуулгын шаардлага:

- Сэдэвтэйгээ уялдсан байх.
- Гаргалгаа, нотолгоо, дүгнэлт сайтай байх.
- Хэл найруулга, бичгийн стандарт хангасан байх.
- Ашигласан эх сурвалжаа тодорхой дурдсан байх.

Үнэлгээ: 100 оноо

- Үгийн тоо (5 оноо)
- Үг үсгийн алдаа (5 оноо)
- Бичгийн стандарт (10 оноо)
- Ашигласан материал, эх сурвалж дурдсан байдал (10 оноо)
- Агуулгаа бүрэн илэрхийлсэн байдал (10 оноо)



- Шинэлэг санаа (10 оноо)
- Найруулга зүй (10 оноо)
- Логик дэс дараалал (10 оноо)
- Баримт нотолгоо дээр тулгуурласан байдал (10 оноо)
- Энгийн ойлгомжтой байдал (10 оноо)
- Уншихад сонирхолтой байдал (10 оноо)



Үр дүнг тайлагнах

Бүртгүүлэгчдийн ур чадварын шалгалтын оноог 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр /өвлийн элсэлтийн хувьд ЭШ-ын сүүлийн өдөр/ ХИС-ийн Элсэлтийн бүртгэлийн системд бүрэн оруулсан байна.

---000---